

# СОЁМБО МЭДЭЭ

**Өнөөдөр**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД БХЯ-НД АЖИЛЛАНА

Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ энэ өдөр БХЯ, ЗХЖШ-ын үйл ажиллагаатай танилцана. Тэрээр "Бүх цэргийн Их Хар сүлд"-нд хүндэтгэл үзүүлээд Монгол Улсын Зэвсэгт хүчинд шинээр нэвтрээд байгаа болон шинэчилсэн зэвсэглэл, техниктэй танилцах юм. Үүний дараа түүнд БХЯ, ЗХЖШ-ын

холбогдох албан тушаалтнууд "Дэлхийн цэрэг-улс төрийн байдал", "Батлан хамгаалах яамны 2020-2024 онд дэвшүүлсэн бодлого, зорилт", "Зэвсэгт хүчний өнөөгийн байдал, хөгжлийн чиг хандлага" сэдвүүдээр мэдээлэл өгөх юм. Төгсгөлд нь Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнэ БХЯ, ЗХЖШ-ын удирдлагад үүрэг чиглэл өгнө.

## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ БОЛНО

Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн хүрээнд "Монгол Улсын Зэвсэгт хүчний нэгэн зууны түүхэн хөгжил 1921-2021" сэдэвт эрдэм шинжилгээний онол арга зүйн хурал өнөөдөр УБХИС-ийн "Сүбээдэй" танхимд зохион байгуулагдана.

Тус эрдэм шинжилгээний бага хуралд ЗХЖШ-ын дарга, хошууч генерал Д.Ганзориг "Монгол Улсын Зэвсэгт хүчний нэгэн зууны түүхэн хөгжлийн замнал, өнөө ба ирээдүй" сэдвээр үндсэн илтгэлийг хэлэлцүүлэх бол ЗХЖШ-ын Бодлого, стратегийн төлөвлөлтийн газрын дарга, бригадын генерал Ч.Цогтжаргал "Төрлийн цэргийг хөгжүүлэх бодлого, хэрэгцээ, шаардлага", Зэвсэгт хүчний Кибер аюулгүй байдлын командлагч, хурандаа Д.Баасандамба "Зэвсэгт хүчний сургалтын тогтолцоог шинэчлэх арга зам", ЗХЖШ-ын Бодлого, стратегийн төлөвлөлтийн газрын Цэргийн бодлогын хэлтсийн дарга, хурандаа Ш.Амарбаясгалан "Энхийг дэмжих ажиллагаа дахь монгол цэргийн оролцоо Зэвсэгт хүчний хөгжлийн нэгэн тулгуур болох нь", Зэвсэгт хүчний Барилга-Инженерийн цэргийн удирдах газрын дарга, хошууч Д.Жаргалсайхан "БНМАУ-ын хөгжилд Барилгын цэргийн оруулсан хувь нэмэр, Монгол Улсын стратегийн бүтээн байгуулалтад Барилга-Инженерийн цэргийн оролцоо, цаашдын хандлага" хавсралт илтгэлийг хэлэлцүүлэх юм.

## ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 124 ДҮГЭЭР АНГИ ШИНЭ ТАНХИМТАЙ БОЛЛОО

Энэ онд ахлагчийн бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлэх хүрээнд "Зэвсэгт хүчний ахлагчийн бүрэлдэхүүний бие бялдрын бэлтгэлжилт, эрүүл мэндийг дээшлүүлэх жил" болгон зарласантай холбогдуулан Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн бүрэлдэхүүн өөрсдийн

дотоод нөөц бололцоондоо тулгуурлан шинээр бялдаржуулах танхимтай болсон байна. Нээлтийн ажиллагаа өнөөдөр болох бөгөөд ЗХЖШ-ын Сургалтын бодлого, зохицуулалтын хэлтсийн биенийн тамирын тасгийн дарга, хурандаа Д.Цог-Эрдэнэ оролцоно.

**Маргааш**

## БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД СЭТГҮҮЛЧИДТЭЙ УУЛЗАНА

Хэвлэл, мэдээллийн байгууллагын ажилтнуудтай хийх "Цэргийн бэлтгэл сургалт" арга хэмжээ Хужирбулан дахь сургалтын нэгдсэн төвд зохион байгуулагдана. Тус

арга хэмжээнд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр оролцож сэтгүүлчидтэй зангиагүй уулзалт хийх юм.

## ГАР ЗУРГИЙН УРАЛДААНЫ ШИЛДГҮҮДИЙН ШАГНАЛЫГ ГАРДУУЛНА

Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойг тохиолдуулан Зэвсэгт хүчний Жанжин штабаас Батлан хамгаалах яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, аймаг, нийслэл, дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабуудтай хамтран "Монгол Улсын Зэвсэгт хүчин-100" сэдэвт гар зургийн уралдааныг оюутан, сурагчдын дунд зохион байгуулан шилдгүүдэд шалгаруулсан. Тус уралдааны шилдгүүдэд шагнал гардуулах ёслолын

арга хэмжээ Монгол Цэргийн музейд зохион байгуулагдана. Уралдаанд 800 гаруй оюутан, сурагчийн бүтээл ирсэн бөгөөд таван насны ангиллаар шалгарсан шилдэг 50 гаруй гар зургийг 3 дугаар сарын 12-ны өдрөөс 3 дугаар сарын 15-ны өдөр Монгол цэргийн музейд дэлгэж олон нийтийн хүртээл болгоно. Үргэлжлүүлэн 3 дугаар сарын 17-ны өдөр "Төрийн ордон"-д дэлгэх юм. Түүнчлэн шилдэг 100 гар зургаар зургийн альбом бүтээж, ерөнхий боловсролын сургуулиудад тараах аж.

**ҮЙЛ ЯВДАЛ**

## "САНСАР СУДЛАЛ БА САНСРЫН ТЕХНОЛОГИ"



Монгол хүн сансарт ниссэний 40 жилийн ойн хүрээнд "Сансар судлал ба сансрын технологи" эрдэм шинжилгээний бага хурал яг энэ цаг үед ШУА-д болж байна. Хуралд Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр оролцож байгаа бөгөөд бусад оролцогчид хандан Монгол хүн сансарт ниссэний болон сансарт хамтран ниссэний 40 жилийн ойн мэндчилгээ дэвшүүлэх юм. "Сансрын бодлого, хэрэгцээ", "Сансар огторгуйн ба ертөнцийн үүсэл", "Сансрын технологи ба батлан хамгаалах" гэсэн гурван үндсэн хэсгээс бүрдэж буй тус хуралд "Сансрын тандан судлал ба байгаль орчны глобал", Монгол Улсын Шинжлэх Ухаан дахь сансрын тандан судлалын хөгжил", "Монголын нутаг дэвсгэрийн геологи, динамик хөгжлийн сансрын цогц судалгааны зарим шинэлэг үр дүн" гэсэн олон сонирхолтой сэдвүүдээр эрдэмтэд хэлэлцэж байгаа юм.

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 160 дугаар тогтоолоор Зөвлөлт-Монголын хамтарсан сансрын нислэг, Монгол хүн сансарт ниссэний 40 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх Засгийн газрын ажлын хэсэг байгуулагдаж тусгай төлөвлөгөө батлагдсан. Үүний хүрээнд ОХУ-ын Улаанбаатар дахь Оросын шинжлэх ухаан, соёлын төв, Монгол Улсын Шинжлэх ухааны Академи, ШУА-ийн харьяа Одон орон, геофизикийн хүрээлэнгээс хамтран тус бага хурлыг зохион байгуулж байна. Гол зорилго нь Зөвлөлт-Монголын хамтарсан нислэгийн судалгаа шинжилгээ, орчлон ертөнцийн үүсэл хөгжил, зайнаас тандан судлал ба геоинформатик, сансрын технологийн хэрэгцээ, пуужин болон хиймэл дагуулын судалгаа хөгжүүлэлт түүний чиг хандлага зэрэг түүхэн үйл явдалтай холбоотой асуудлаар эрдэмтэн, судлаачид, бодлого боловсруулагч, хэрэглэгч сонирхогч, хүүхэд залуучуудад мэдлэг мэдээлэл түгээхэд оршиж байгаа аж.

**МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР**

## ТҮҮХТ ОЙГ УГТАЖ ...



Орчин цагийн Зэвсэгт хүчний 100 жилийн ойг тохиолдуулан аймаг, орон нутгийн удирдлага, ЗДТГ-ын Цэргийн штабаас хүүхэд, залуучуудад цэрэг-эх оронч үзлийг төлөвшүүлэх, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, ахмад дайчдынхаа алдар гавьяаг мөнхжүүлэх зорилгоор бүтээлч ажил, арга хэмжээг өрнүүлсээр байна. Тухайлбал, Дорнод аймгийн ЗДТГ-аас Цэргийн штаб, Боловсрол, соёл урлагийн газартай хамтран аймгийнхаа ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд "Монгол цэрэг-100 жил" сэдэвт гар зургийн уралдааныг зохион байгуулжээ. Уралдаанд 55 бүтээл ирснээс А.Төгөлдөр, О.Мөнх-Ундраал, Х.Хүслэн нарын ахлах ангийн сурагчдын зурсан зураг тэргүүлж,

тусгай байрт Д.Мөнх-Эрдэнэ, Т.Батбилэг нарын бүтээл шалгарсан байна. Мөн Дорноговь аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабаас санаачлан гурван үеийн дурсамж уулзалтыг зохион байгуулсан байна. Уулзалтад дайнд оролцсон ахмад дайчдаас өдгөө алба хааж байгаа цэргийн алба хаагчдыг хамруулж, гурван үеийн төлөөлөл эх орон, тусгаар тогтнолын үнэ цэний талаар оюутан, сурагчдад яриа, таниулга хийжээ. Түүнчлэн "Цэргийн дууг хэн сайн дуулах вэ", "Аавдаа захидал бичээрэй" уралдаануудыг аймгийн иргэдийн дунд, "Эх орон юунаас эхэлдэг вэ" эсээ бичлэгийн уралдааныг ерөнхий боловсролын сургуулийн ахлах, дунд бүлгийн сурагчдын дунд зохион байгуулж, удахгүй дүнгээ гаргах юм байна.

| ЦАГ АГААР   |      |
|-------------|------|
| УЛААНБААТАР |      |
| ӨДӨР        | ШӨНӨ |
| 7°C         | -9°C |
| ӨМНӨД СУДАН |      |
| ӨДӨР        | ШӨНӨ |
| 41°C        | 27°C |
| АФГАНИСТАН  |      |
| ӨДӨР        | ШӨНӨ |
| 14°C        | 3°C  |

| ВАЛЮТЫН ХАНШ |         |         |
|--------------|---------|---------|
| ВАЛЮТ        | АВАХ    | ЗАРАХ   |
| USD          | 2,845.0 | 2,858.0 |
| EUR          | 3,351.0 | 3,416.0 |
| CNY          | 433.20  | 438.00  |
| RUB          | 37.49   | 39.21   |
| JPY          | 25.85   | 26.49   |
| KRW          | 2.44    | 2.56    |

| КОВИД-19 МЭДЭЭ     |      |
|--------------------|------|
| ШИНЭЭР БҮРТГЭГДСЭН | 80   |
| НИЙТ БҮРТГЭГДСЭН   | 3561 |
| ЭДГЭРСЭН           | 2847 |
| НАС БАРСАН         | 8    |

| ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ |     |
|---------------------|-----|
| ШИНЭЭР НЭМЭГДСЭН    | 24  |
| ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ | 189 |
| ЭДГЭРСЭН            | 872 |

**ӨРНИЙН ЗУРХАЙ**

2021.03.12 /БААСАН ГАРАГ/

**ХАВРЫН ТЭРГҮҮН ЦАГААН  
БАР САРЫН ЕСӨН УЛААН  
ШАРАГЧИН ХОНЬ ӨДӨР**

**Үс засуулвал:**  
Сүлд тэнэж одно


**Наран ургах, шингэх:**  
07.11-18.52

**Барилдлага: Шид**  
**Шүтэн барилдлага: Өтлөх үхэхүй**  
**Суудал: Хий**

Аргын тооллын 3 сарын 12, Сугар гараг. Билгийн тооллын 29, Чөдөр одтой, шарагчин хонь өдөр. Өдрийн наран 7 цаг 11 минутад мандан, 18 цаг 52 минутад жаргана. Тухайн өдөр гахай жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буян номын үйлд шамдах, бүтээл туурвил эхлэх, худалдаа арилжаа хийх, бизнес эхлэх, зэрэг дэв дэвших, хишиг даллага дуудуулах, насан бүтээл хийлгэх, мал худалдан авах, мал түгээх, сахил санваар авах, хануур, төөнүүр хийлгэх, хийморийн дарцаг хатгахад сайн. Эрдэнийг гадагш өгөх, уул овоо тахиад муу. Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

## ҮЙЛ ЯВДАЛ

# ТӨЛӨВЛӨЛТИЙН ХУРАЛ ЦАХИМААР ЯВАГДЛАА



Монгол Улсын Зэвсэгт хүчин, Япон Улсын Өөрийгөө хамгаалах хүчний хамтарсан "Чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр"-ийн хүрээнд хэрэгжиж байгаа "Зам" сургалтын 2 дахь удаагийн төлөвлөлтийн хурал өчигдөр цахимаар зохион байгуулагдаж, талууд энэ оны хамтын ажиллагааны төлөвлөлтийн асуудлаар санал

солилцон нэгдсэн ойлголтот хүрлээ.

Төлөвлөлтийн хуралд Монголын талаас Батлан хамгаалах яамны ГХАГ-ын дарга, хурандаа Б.Бат-Эрдэнэ, Хуурай замын цэргийн командлалын Инженерийн дарга, хурандаа С.Содов, Японы талаас Батлан хамгаалах яамны Бодлогын газрын

зөвлөх Мацузава, Чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр хариуцсан хэсгийн дарга Ишицүка нар оролцов. Хоёр улсын Зэвсэгт хүчин хамтран 7 дахь жилдээ "Чадавхыг дээшлүүлэх хөтөлбөр"-ийг амжилттай хэрэгжүүлж байгаа нь Монгол Улсын Зэвсэгт хүчний чадавхыг бэхжүүлэхэд ихээхэн ач холбогдол үзүүлж байгаа хэрэг юм.

# ГУРВАН ҮЕИЙН ДУРСАМЖ УУЛЗАЛТ БОЛОВ

Өмнөговь аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб



Зэвсэгт хүчний түүхт 100 жилийн ойн хүрээнд Батлан хамгаалах бодлого, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг сурталчлах, ахмад дайчдын гавьяаг алдаршуулах, иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх, хүүхэд, залуучуудад

эх оронч үзэл хүмүүжлийг төлөвшүүлэх, улс орны тусгаар тогтнол, түүхэн уламжлалыг түгээх зорилгоор гурван үеийн дурсамж уулзалтыг зохион байгууллаа.

Уулзалтыг "Зэвсэгт хүчин-100 жил" видео танилцуулгаар

эхлүүлсэн бөгөөд Даланзадгад сумын Засаг дарга Х.Батболд болон удирдлагууд, ахмад үеийг төлөөлж аймгийн Ахмадын хорооны дарга, бэлтгэл дэд хурандаа А.Цэсодном, Ш.Энхболд, Д.Бум, Г.Цогт, Ц.Цэнд, бэлтгэл ахлагч З.Лхагвасүрэн, дунд үеийг төлөөлж Зэвсэгт хүчний 167, Хилийн цэргийн 0131 дүгээр анги, онцгой байдлын алба хаагчдын төлөөлөл, залуу үеийг төлөөлж Даланзадгад сумын ерөнхий боловсролын сургуулийн 30 сурагч оролцлоо. Уулзалтаар аймаг орон нутагт байрлан үйл ажиллагаа явуулдаг Зэвсэгт хүчин, Хилийн цэрэг, Онцгой байдлын газрын байгууллагуудын танилцуулгыг хийж ая дууны мэндчилгээ дэвшүүлж ахмад дайчид дурсамж, дурдатгалаа хуваалцсан юм. Мөн энэ үеэр 18 нас хүрсэн 15 сурагчид цэргийн үүрэгтний үнэмлэх гардууллаа.

Дэд хурандаа Д.УЛАМБАЯР

# ТАКТИКИЙН ХЭЭРИЙН СУРГУУЛИЙН ЯВЦТАЙ ЦАХИМААР ТАНИЛЦЛАА

Зэвсэгт хүчний 339 дүгээр анги 3 дугаар сарын 3-5-ны өдрүүдэд хээрийн гаралтаа зохион байгуулж төгсгөлд нь тактикийн хээрийн сургуулийг явууллаа. Тус сургуулийн явцтай ЗХЖШ-ын Сургалтын бодлого, зохицуулалтын хэлтсийн дарга, хурандаа Ш.Гантулга, Зэвсэгт хүчний Барилга-Инженерийн цэргийн удирдах газрын орлогч дарга, хурандаа Ц.Ганхөлөг нарын албаны хүмүүс цахимаар танилцлаа. Тактикийн хээрийн сургуультай цахимаар танилцсан нь анхны тохиолдол юм.

Сургуулийн төгсгөлд хурандаа Ш.Гантулга, хурандаа Ц.Ганхөлөг нар цар тахлын нөхцөл байдалтай уялдуулан Зэвсэгт хүчний хэмжээнд техник, технологийн дэвшлийг ашиглан цахимаар сургалт, цугларалтыг явуулан хэвшиж байгааг онцлоод тус анги нь Зэвсэгт хүчний Барилга-Инженерийн цэргийн удирдах газрын харьяа ангиудаас анх удаа тус сургуулийг зохион



байгуулсныг тодотгов. Энэхүү сургууль нь цэргийн алба хаагчдын ур чадвар, бэлтгэлжилтийн түвшин, зэвсэглэл техникийн бэлэн байдлыг дээшлүүлэх, салбаруудын харилцан ажиллагааг бэхжүүлэхэд үр

дүнгээ өгсөн зэрэг олон талын ач холбогдолтой боллоо. Түүнчлэн сургуулийн явцыг Баянхонгор аймгийн удирдлага, төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын дарга, алба хаагчид үзэж сонирхсон юм.

# ААВ, ЭЭЖДЭЭ ЗАХИДАЛ ИЛГЭЭЛЭЭ

013 дугаар анги

Ангийн эмэгтэйчүүдийн зөвлөлөөс хугацаат цэргийн алба хаагчдад тус бүр 3 ширхэг амны хаалт оёж өглөө. Мөн ангийн нийт хугацаат цэргийн алба хаагчид "Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр"-өөр ээжүүддээ, "Монгол цэргийн

өдөр", Зэвсэгт хүчний 100 жил"-ийн ойг тохиолдуулан аавууддаа захидал бичиж Улаанбаатар хотын дүүргүүд болон хөдөө орон нутагт шуудангаар илгээн баярын мэндчилгээ дэвшүүллээ.

"Монгол цэргийн өдөр", Зэвсэгт хүчний 100 жил"-ийн

ойн баярын хүрээнд зохион байгуулагдаж байгаа гар зураг, шүлгийн уралдаанд нийт хугацаат цэргийн алба хаагчид идэвх санаачилга гарган оролцож байна.

Хошууч С.БАТБААТАР

## ЦАХИМ ШУУДАНД

# "МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР"-ИЙГ УГТАЖ ОЛОН БҮТЭЭЛЧ АЖИЛ ӨРНҮҮЛЭЭД БАЙНА

350 дугаар анги

Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд мэдээлэл сурталчилгаа, олон нийтийн ажил, урлаг соёл, спортын уралдаан тэмцээнүүдийг амжилттай зохион байгууллаа.

Тухайлбал, бие бүрэлдэхүүнийг ардын дууны өв сангаас суралцан урын сангаа баяжуулах, мартагдсан дууг сэргээн дуулах, өвлөх, ардын авьяастнуудыг алдаршуулах, өсвөр залуу хойч үеийнхэнд

зааж сурган, сурталчлан таниулах түгээн дэлгэрүүлэх, тэдний уялдаа холбоог бий болгох үүднээс "Ардын дууг хэн сайн дуулах вэ" уралдааныг цахимаар зохион байгууллаа. Тус уралдаанд 12 цэргийн алба хаагч өөрсдийн сонгосон дуугаар оролцсоноос тэргүүн байрыг ахлагч Б.Номин-Эрдэнэ, дэд байрыг ахлагч Д.Мөнх-Очир, гутгаар байрыг тасгийн захирагч Б.Дашцэрэн, тасгийн захирагч Б.Даваабаатар нар тус тус эзлэв.



Мөн Монгол хүн сансарт ниссэний 40 жилийн ойд зориулан алба хаагчдын хүүхдүүдэд сансар огторгуйн талаар ойлголт өгч, монгол хүн сансарт мөрөө гаргаж эх орныхоо нэрийг дэлхий дахинд дуурсгасан үйл явдлаар бахархал төрүүлэх зорилгоор "Гар зургийн уралдаан"-ыг цахимаар зохион байгууллаа. Тус уралдаанд нийт 21 бүтээл ирснээс тэргүүн байрт Б.Хулан /6-9 нас/, О.Золжаргал /10-13 нас/ нарын бүтээл шалгарав.

Түүнчлэн ангийн офицеруудын оюуны мэдлэгийг тэлэх, илтгэх ур чадварыг нэмэгдүүлэх, монгол цэргийн түүхэн дахь бахархам үйл явдлуудыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Цэргийн үүсэл хөгжил" сэдвээр илтгэлийн уралдааныг мөн цахимаар зохион байгуулснаас ахмад Д.Баасандорж, ахмад Т.Эрдэнэсайхан, ахлах дэслэгч Т.Нацагдорж нар эхний гурван байрыг эзэлсэн юм.

Ангийн ахлагч нарыг ажил албаараа бахархах, үе

үеийн хамтран ажиллаж байсан хамт олны харилцаа, холбоог сайжруулах, бичих ур чадварыг хөгжүүлэх, бие даасан бүтээлч сэтгэлгээгээ нэмэгдүүлэхэд туслах замаар цэргийн нөхөрлөл бол хамгийн нандин, үүрдийн үерхэл байдаг гэдгийг тодотгон харуулах зорилгоор "Монгол цэрэг-Дэлхийн цэрэг" эсээ бичлэгийн уралдааныг явууллаа. Тус уралдаанд ахлагч У.Бат-Эрдэнэ, сургагч ахлагч М.Батмөнх, ахлагч Ч.Пүрэвбат нар бусдыгаа манлайлан оролцов.

"Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг тохиолдуулан ангийн нийт эмэгтэйчүүдийн дунд бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, гар урлалын бүтээл гаргах, олон нийтийн үйл ажиллагаанд эмэгтэйчүүдийн оролцоо, идэвхийг нэмэгдүүлэх зорилгоор "Гар урлалын бүтээл"-ийн уралдааныг зохион байгуулан явуулав. Тус уралдааны эхний гурван байрт Б.Од-Эрдэнэ, Ж.Отгончимэг, Л.Байгальмаа нарын бүтээлүүд шалгарчээ.



Ахмад Б.ДЭРДЭНЭНИНЖ

# ГАРНИЗОНЫ "ХАМГИЙН ХАМГИЙН"-УУД ТОДОРЛОО

336 дугаар анги

"Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр"-ийг тохиолдуулан ангийн удирдлага, эмэгтэйчүүдийн зөвлөл хамтран ангийнхаа эмэгтэй цэргийн алба хаагчдын дундаас шилдгүүдээ тодрууллаа. Үүнд "Мөрдэст гоо

бүсгүй"-ээр нярав, ахлах ахлагч Н.Бадамханд, "Манлайлагч гоо бүсгүй"-ээр ээлжийн тогооч, ахлах ахлагч Э.Насанбаяр, "Хөдөлмөрч гоо бүсгүй"-ээр үйлчлэгч Х.Мөнхчулуун нар тус тус тодорлоо.



Дэслэгч Ч.БОДЫГЭРЭЛ



СОЁМБО СОНИН

"Соёмбо" сонин 97 дахь жилдээ хэвлэгдэж байна.  
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА,  
Д.НАЦАГДОРЖ

Дарга, ерөнхий редактор  
Хурандаа  
САНЖМЯТАВЫН  
ТӨМӨРХУЯГ

Эхийг "Соёмбо"  
сонини редакцияд  
бэлтгэв.

\*Зар, рекламьг хямд нийтэлнэ.  
\*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.  
\*Зохиогчийн үзэл болон сонини нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.  
\*Тус сонини мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот,  
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон  
Индекс 10018

И-мэйл хаяг:  
Soyombo@mod.gov.mn  
Утас: 70001029